

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 23 оны 09 сарын 15 өдөр

№ SR-2023-21

Улаанбаатар хот

ХасБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд  
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1, 29.2.2 дахь заалт, ХасБанк ("Банк")-ны хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн SR-2023-03 дугаартай тогтоолоор эрх олгосны дагуу, Монголбанкны 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А-1/374 дугаартай албан бичгээр өгсөн зөвшөөрөл, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 179 дугаартай тогтоолд тус тус үндэслэн, Банк нь 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцааг нийтэд анх удаа санал болгон Монголын хөрөнгийн биржээр худалдаж, 35,677,900,000 (гучин таван тэрбум зургаан зуун далан долоон сая есөн зуун мянга) төгрөгийг татан төвлөрүүлснийг;
2. Нийтэд анх удаа санал болгон хувьцаа гаргахтай холбоотой гарсан зардал 1,638,905,180 (нэг тэрбум зургаан зуун гучин найман сая есөн зуун таван мянга нэг зуун ная) төгрөг болсон, татан төвлөрүүлсэн хөрөнгөөс энэ дүнг цэвэршүүлэн хасаад өөрийн хөрөнгө 34,038,994,820 (гучин дөрвөн тэрбум гучин найман сая есөн зуун ерэн дөрвөн мянга найман зуун хорь) төгрөгөөр нэмэгдсэнийг;
3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,270,000,000 (таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөгөөр, нэмж төлөгдсөн капитал 28,768,994,820 (хорин найман тэрбум долоон зуун жаран найман сая есөн зуун ерэн дөрвөн мянга найман зуун хорь) төгрөгөөр тус тус нэмэгдэж ийнхүү нийт өөрийн хөрөнгө 34,038,994,820 (гучин дөрвөн тэрбум гучин найман сая есөн зуун ерэн дөрвөн мянга найман зуун хорь) төгрөгөөр нэмэгдэж буйг;
4. Ийнхүү анхдагч зах зээлд хувьцаагаа амжилттай байршуулснаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болсныг; мөн
5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг тогтоож батлах, түүний дагуу Банкны дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусгах эрх Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд хадгалагддаг болохыг тус тус тэмдэглэв.

**ТОГТООХ нь:**

1. ХасБанкны зарласан болон гаргасан энгийн хувьцааны тоог нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг болгон тус тус тогтоож, хувь нийлүүлсэн хөрөнгийг 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.
2. ХасБанкны хувьцаат компанийн дүрмийн төсөлд дээрх агуулгыг тусган ХасБанк хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд зохих эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА